



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/1436

Улаанбаатар хот

Нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 146 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11/34 дүгээр, 2022 оны 51, 65 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх ажлын хүрээнд худалдаж авах нийтийн тээврийн автобусны нэр төрөл, тоо хэмжээг хавсралтаар баталж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/967 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн нийлүүлэгчтэй холбогдох хууль, журамд нийцүүлэн гэрээ байгуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү)-т даалгасугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан нийтийн тээврийн автобус худалдаж авахад шаардлагатай 60,560.4 (жаран тэрбум таван зуун жаран сая дөрвөн зуун мянга) сая төгрөгийг “Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний шинэчилсэн жагсаалт”-ын “Авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын “19”-д заасан “Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлт”-ийн хөрөнгөөс холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Мишээлт)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Нийтийн тээврийн газар (Ч.Сайханбаяр)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх тухай” Нийслэлийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/1216 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

111020066612

4.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэнд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



Нийслэлийн Засаг даргын 2022 оны
..11 дүний.. сарын 10-ны өдрийн
..11436.. захирамжийн
хавсралт



НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2022 ОНД НИЙТИЙН
ТЭЭВРИЙН ПАРК ШИНЭЧЛЭЛТ ХИЙХ АЖЛЫН ХҮРЭЭНД
ХУДАЛДАЖ АВАХ АВТОБУСНЫ НЭР ТӨРӨЛ,
ТОО ХЭМЖЭЭ

				/сая төг/
№	Төсөл, арга хэмжээний нэр, төрөл	Хугацаа	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн
1	Их багтаамжийн дизель хөдөлгүүртэй автобус /224 ширхэг/	2022-2023	61,625.4	60,560.4
Дүн			61,625.4	60,560.4